



СЭЛЭНГЭ АЙМАГ
ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/41

Жаргалант

Онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дугаар зүйлийн 29.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Болзошгүй байгалийн, хүний, техникийн болон технологийн хамааралтай аюул, ослоос урьдчилан сэргийлэх, гамшгийн нөхцөл байдал үүссэн үед шуурхай хариу арга хэмжээ авах, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах сумын Онцгой комиссын бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Онцгой комисс ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжоор хүлээсэн эрх, үүрэг Онцгой комиссын ажиллах журмыг хэрэгжүүлэн ажиллахыг нийт гишүүдэд үүрэг болгосугай.

3.Онцгой комиссын гишүүдийн хувийн бэлтгэл, бэлэн байдал, Онцгой комиссын үйл ажиллагааны тогтвортой ажиллагааг бүрдүүлж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой комиссын орлогч даргад даалгасугай.

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн А/148 дугаар захирамжийг хүчингүйд болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.ОТГОНДАЛАЙ.